

Мөнхөөгийн Баярсайхан[✉]

¹Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэн
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө,
Шинжлэх ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

Төмстийн өврийн булшнаас илэрсэн мал, амьтны зүлд

Хураангуй. Монгол-Туркийн хамтарсан “Туулын хөндий дэх Хөх Түрэг, Уйгурын суурингууд” төслийн археологийн хайгуул, малтлага судалгааны хээрийн шинжилгээний анги 2025 онд Төв аймгийн Заамар сумын нутаг Төмстийн өвөр гэдэг газарт гурван булш малтан судалсан. Малтлага судалгаагаар илэрсэн адуу, үхэр, хонь, нохойн толгой, мөчдийн ясанд палеозоологийн судалгааны ажил хийж гүйцэтгэв.

Түлхүүр үг: Булш, палеозоологи, зооархеологи, адуу, үхэр, хонь, нохой, зүлд

Bayarsaikhan Munkhuu[✉]

¹Institute of Archaeology,
Mongolian Academy of Sciences Building-1,
Peace Avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

Animal sacrifice from the burial Tumstiin Uvur

Abstract. In 2025, the field research team of the Mongolian-Turkish joint project “Turkic and Uyghur Settlements in Tuul Valley” conducted archaeological survey and excavation at a site known as Tumstiin Uvur, located in Zaamar sum, Tuv Province, Mongolia. During the excavation, three burial sites were investigated. The study resulted in the discovery and analysis of paleozoological remains, including skulls and limb bones of horses, cattle, sheep and dogs.

Keywords: Tomb, paleozoology, zooarchaeology, horse, cattle, sheep, dog, animal sacrifice

Удиртгал

Монгол улсын Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн БНТУ-ын Измирийн Катип Чэлэби Их Сургууль (ИКЧИС)-ийн Нийгмийн Ухааны Факультет, МУИС-ИКЧИС-ийн Түрэг Судлалын Хүрээлэнтэй хамтран Төв аймгийн Заамар сумын нутаг Агьт, Төмст уулын орчимд, Туул голын хойд эрэгт байрлах Хэрмэн дэнжийн балгас буюу “Тугу Балык”-ийн орчимд “Туулын хөндий дэх Хөх түрэг, Уйгурын суурингууд” төслийн хүрээнд археологийн малтлага, хайгуул судалгааны ажлыг 2024 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн билээ.

2025 онд Хэрмэн дэнж - 1, Төмстийн өвөр, Агьтын Ар үзүүр хэмээх гурван газар археологийн малтлага судалгааны ажил гүйцэтгэсэн (Энхтөр нар, 2025). Хэрмэн дэнжийн баруун хойд талд Төмст уул оршино. 2024 оны хайгуулаар Төмстийн өвөр хэмээх газар бүлэг булш илрүүлсэн. Энэхүү дурсгал нь Төмст уулын урд талын өргөн амны баруун хэсэгт орших жижиг мухар аманд байрлах бөгөөд бусад үеийн оршуулгын газруудаас ялгаатай, нууцлаг байрлалтайгаар байгуулагдсан байна. Жижиг толгойн урд энгэрт, уулнаас буусан хоёр жалгын хоорондох дэвсгэр дээр цөөн тооны дараас чулуутай зургаан булш байна. Энэхүү оршуулгын газрын булшнаас гурван дурсгалыг сонгон авч малтан судалсан. Эртний нүүдэлчид нь өөрсдийн булш оршуулгадаа адуу, том эвэртэй үхрийн толгой, хонь, нохойн толгой, бусад биеийн хэсэг, мөчдийг тахил, тайлгын зорилгоор дагалдуулан байрлуулдаг байжээ.

Судалгааны арга зүй

Палеозоологийн судалгааны арга зүйн дагуу ясны олдворуудыг шорооноос нь ялган авч, угаан цэвэрлэж, ямар төрөл, зүйлийн амьтдын яс болохыг судлаач С.Андрейн гарын авлага ашиглан тодорхойлсон (Андрей 1997). Үүний дараа гэрэл зураг авч баримтжуулан, мал, амьтны толгойн ясаар нас, хүйс, өвчлөлтийг тодорхойлов. Краниологи, остеологийн хэмжилт хийхдээ судлаач С.Дуламцэрэнгийн “Хөхтөн амьтан тодорхойлох бичиг” (Дуламцэрэн 1970), мөн мал, амьтны яс хэмжихэд хэрэглэдэг дараах багаж хэрэгслийг ашиглав (Driesch 1976).

1. Гулгуур хэмжүүр /Slide gauge with vernier scale/.
2. Гулгуур хэмжүүр /Dial slide gauge/.

Судалгааны хэрэглэгдэхүүн, палеозоологийн материалын хадгалагдсан байдал

Төмстийн өврийн оршуулгын газрын 1, 3, 6-р дугаартай булшинд археологийн уламжлалт арга зүйн дагуу малтлага судалгааны ажил гүйцэтгэхэд

эд өлгийн олдвор хэрэглэгдэхүүнээс гадна хүн, мал, амьтны ясны олдвор илэрсэн (Зураг 11).

Төмстийн өврийн 1-р булш. Оршуулгын газрын хамгийн зүүн талын булш бөгөөд 60 см-ийн гүнээс оршуулсан хүний өвдөгний харалдаа хошууг нь хойд зүгт харуулан тавьсан эвэртэй үхрийн толгой, доод эрүүний ясны хамт 1 илэрсэн (Зураг 1-4). Үхрийн толгойн ястай хамт хавирга, дөрвөн шийр, сүүлний яс хамт олдсон. Үүнээс үзэхэд уг зүлдийг арьсанд нь ороож тавьсан бололтой. Зүлдийг баримтжуулан авсны дараа доош ахин нэг үе малтахад мөн адууны толгойн яс илэрсэн (Зураг 5). Эдгээр зүлдээс үзэхэд хүнийг оршуулсны дараа нэг үе чигжээс хийж, бог мал, адуу, үхрийн зүлдийг давхарлан, үе үеэр дээш ахиулах байдлаар байрлуулсан бололтой (Зураг 10). Хүннүгийн үеийн булш оршуулгын зүлд дагалдуулах тусгай хөмөг хүний толгойн талд байдаг бөгөөд энэхүү булш нь оршуулгын нүхэнд нь хүний дээр зүлд тавьснаараа онцлог байлаа. Том эвэртэй үхрийн толгойн яс маш муу хадгалагдсан байв. Харин адууны толгойн яс хадгалалтын хувьд дунд зэрэг. Доод эрүүний яс нь хугарсан байдалтай олдсон. Бүх зүлдийг авч дууссаны дараа хүний оршуулга илэрсэн (Зураг 9).

Төмстийн өврийн 3-р булш. Энэхүү булш нь тус оршуулгын газрын зүүн талаас илэрсэн гурав дахь булш юм. 1-р булштай харьцуулахад харьцангуй гүехэн байв. Малтлага 1 м гүн болоход оршуулга илэрсэн бөгөөд тоногдсон байв. Оршуулгын түвшинд нэг үед нь хонины толгойн яс маш их хэмхэрхий, гэмтэл ихтэй байсан тул хэмжилт хийх боломжгүй байв. Харин аман хүзүү, хатан хүзүү, хавирга, ууцны яс харьцангуй сайн хадгалагдан үлдсэн байна (Зураг 8).

Төмстийн өврийн 6-р булш. Тус булш нь дээрх оршуулгын газраас багахан зайтай буюу урд зүгт жалга уруудаад 200 орчим метр зайд байрлана. Хэмжээний хувьд харьцангуй том 12 м голчтой чулуун дараатай булш юм. Малтлага 230 см-ийн гүн болоход булшны хөл талаас нохойн яс илэрсэн. Гэвч тонуулчдын нөлөөгөөр толгойн яс бяцарч, хэмжилт хийх боломжгүй олон жижиг хэсэг болон үйрч бутарсан бөгөөд нийтдээ маш муу хадгалагдсан байна (Зураг 7).

Хүснэгт 1. Төмстийн өврийн булшинаас илэрсэн мал, амьтны толгойн яс

	Амьтны нэрс	Амьтны латин нэр	Булшны дугаар	Тоо, хэмжээ
1.	Үхэр	Bos taurus	1	1
2.	Адуу	Equus caballus	1	1
3.	Хонь	Ovis	3	1
4.	Нохой	Canis familiaris	6	1

Судалгааны үр дүн

Малтлага судалгаагаар булшнаас хүний бүрэн бүтэн араг яс, булш оршуулга дотор тахил тайлгын журмаар дагалдуулж тавьсан том эвэртэй үхрийн толгойн яс, адуу, хонь, нохойн толгойн яс, хүзүү болон бусад мөчдийн яс илэрсэн нь эртний нүүдэлчдийн зүлдийг эрхгүй санагдуулж байна. (Хүснэгт 1).

Малтлагаар илэрсэн мал, амьтны яснуудыг эхний ээлжид хээрийн нөхцөлд цэвэр усаар угааж, сүүдэр газар хатаан, судалгаанд бэлтгэсэн.

Харин Төмстийн өврийн 1-р булшнаас илэрсэн үхрийн толгойн яс нь хөрсөнд байхдаа маш муу хадгалалттай байсан учраас тээвэрлэлтийн ачааллыг даах боломжгүй. Иймд эхний ээлжид усаар угаалгүй, модон савх, багсаар дагтаршсан шороог цэвэрлэсний дараа баримтжуулалтын зорилгоор гэрэл зураг авч, краниологийн хэмжилт, судалгаа хийв (Хүснэгт 2).

Үхрийн толгойн ясны духны яс (*Os frontale*), үүдэн шүдний яс (*Os incisivum*), хамрын яс (*Os nasale*), зулайн яс (*Os parietale*) ихээхэн хэмжээгээр эвдэрч гэмтсэн байв. Хэмжилт судалгааны явцад үхрийн дээд эрүүний том араа шүднүүд бусад шүднээс илүү элэгдэлд орсон бөгөөд патологийн шинж тэмдэг илэрсэн.

Хүйсийг тодорхойлоход том соёо бүхий яс эр амьтных болох нь тогтоогдов. Ерөнхийдөө соёо нь эр амьтны дээд, доод эрүүнд байрладаг бол гүүнд соёо маш ховор тохиолдож, ихэвчлэн зөвхөн доод эрүүнд сул хөгжсөн байдлаар илэрдэг (Климов 1969).

Төмстийн өврийн 3-р булшнаас илэрсэн хонины толгойн ясны духны хэсэг бүтэн үлдсэн боловч бусад хэсгүүд нь эвдэрч, олон хуваагдсан байдалтай байв. Мөн булшнаас бог малын доод эрүү, аман хүзүү, хатан хүзүү, хавирга, ууцны яснууд хамт илэрсэн. Толгойн яс нь краниологийн хэмжилт хийх боломжгүй байв.

Төмстийн өврийн 6-р булшнаас илэрсэн нохойн толгойн яс эвдэрч хэмхэрсэн, муу хадгалалттай учир зөвхөн доод эрүүний яс, шүд үлдсэн байв. Шүдний цөгцний элэгдлээр амьтны насыг тодорхойлдог бөгөөд үхэр, адууны толгойн ясны хувьд нас бие гүйцсэн (*adultus*) амьтныг илэрхийлж байна.

Хүснэгт 2. Үхэр, адууны толгойн ясанд хийсэн краниологийн хэмжилтийн мэдээлэл

№	Үхрийн толгойн ясны хэмжилт	Хэмжээ (см)
1.	Гавлын их урт	54
2.	Кондилобазаль урт	49
3.	Үндсэн урт	46
4.	Их өргөн	23,1
5.	Ухархай хоорондын зай	18,3
6.	Чамархайн өргөн	16,4
7.	Нүүр хэсгийн урт	35

8.	Хамар ясны урт	-
9.	Арааны түүшийн (эгнээний) урт	12

№	Адууны толгойн ясны хэмжилт	Хэмжээ (см)
1.	Гавлын их урт	51
2.	Кондилобазаль урт	49
3.	Үндсэн урт	47
4.	Их өргөн	20,2
5.	Ухархай хоорондын зай	14,6
6.	Чамархайн өргөн	14
7.	Нүүр хэсгийн урт	33,5
8.	Хамар ясны урт	8
9.	Арааны түүшийн (эгнээний) урт	17

Дүгнэлт

Тус оршуулгын газарт талийгаачдад дагалдуулсан зүлдийг тусгай хөмөгт биш оршуулгын нүхэнд хүний дээр дагалдуулсан нь Хүннүгээс эрс ялгаатай байгааг харуулж байна. Бидний таамаглаж буйгаар Сяньбигийн үед холбогдож болзошгүй Төмстийн өврийн 1-р булшинд хүнийг оршуулахдаа эвэртэй үхрийн толгой (*bos taurus*), богино хавирга, дөрвөн шийр, сүүлний годон яс, мөн адууны толгой (*equus caballus*) дагалдуулан тавьсан байна. Харин 3-р булшинд бог мал болох хонины толгой (*ovis aries*), аман хүзүү, хатан хүзүү, хавирга, ууцны ясыг хамтад нь байрлуулж, бүтэн амьтныг төлөөлүүлэн зүлдэлсэн байжээ.

6-р булшинд нохойн толгой (*canis familiaris*) илэрсэн бөгөөд бусад их бие, мөчдийн ясны байрлалаас үзэхэд анх бүтнээр нь хойлголон тавьсан бололтой. Харин уг булш тонуулсны улмаас нохойн яс ихээхэн эвдэрч хэмхэрсэн байна.

Хонь, нохойн толгойн ясан дээр нас, хүйсийг тодорхойлох боломжгүй байсан бөгөөд булшинд байхдаа тонуулчдын нөлөөгөөр олон жижиг хэсэг болон эвдэрч хэмхэрсэн байна (Зураг 12).

Үхрийн толгойн ясны дээд эрүүний арын хоёр араа шүд ихэд элэгдэж мөлийсөн байдалтай байсан бөгөөд өвчлөлийн патологийн шинж тэмдэг илэрсэн.

Эдгээр краниологи, остеологийн нарийн хэмжилт, судалгааны үр дүнд эртний нүүдэлчдийн малын төрөл, үүлдэр, нас, хүйсний бүтэц, мал аж ахуйн хэв шинжийн талаар цаашид өргөн хүрээний мэдээлэл олж авах боломж бүрдэх юм. Тус оршуулгын газраас илэрсэн зүлд нь ширэнд нь ороож тавьсан мэт шинжтэй нь үхрийн годон яс, шийр зэргийн байрлалаас харагдаж байна.

Талархал

Төмстийн өврийн дурсгалыг хайгуул судалгаагаар олж илрүүлэн малтан судалж мал, амьтны ясны судалгаа хийж гүйцэтгэх боломж олгосон ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн

Дундад зууны салбарын эрдэм шинжилгээний ажилтан доктор /Ph.D/ Г.Батболддоо гүн талархал илэрхийлье.

НОМ ЗҮЙ

Андрей С. Гэрийн амьтдын ясны жишил анатоми. The comparative anatomy of the domestic animals. Улаанбаатар, 1997: 12-25.

Дуламцэрэн С. Хөхтөн амьтан тодорхойлох бичиг. Улаанбаатар, 1970: 240.

Энхтөр А., Доган Ш., Йылмаз А., Мөнхтулга Р., Баярсайхан М., Батболд Г., Амартүвшин Н., Вардар С. “2025 онд Хэрмэн дэнж ба түүний орчимд гүйцэтгэсэн малтлага судалгааны урьдчилсан үр дүн”. *Монголын археологи-2025*. Эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. Улаанбаатар, 2025: 390-396.

Энхтөр А., Батболд Г., Баярсайхан М., Монгол-Туркийн хамтарсан “Туулын Хөндий дэх Хөх Түрэг, Уйгурын суурингууд” төслийн археологийн малтлага судалгааны ажлын тайлан. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн ГБСХ. Улаанбаатар, 2025: 89.

Климов А. Ф., Гэрийн амьтдын анатоми. I боть. Улаанбаатар, 1969: 529.

Angela von den Driesch. A Guide to measurement of animal bones from archaeological sites. Peabody Museum of Archaeology and Ethnology. Harvard University, 1976. 137.

REFERENCES

Andrei C. Geriin amitdyn yasni jishil anatomi. The comparative anatomy of the domestic animals. Ulaanbaatar, 1997: 12-25.

Dulamtsereen C. Khukhtun amitan todorkhoilokh bichig. Ulaanbaatar, 1970: 240.

Enkhtur A., Dogan Sh., Iilmaz A., Munkhtulga R., Bayarsaikhan M., Batbold G., Amartuvshin N., Vardar C., 2025 ond Khermen denj ba tuunii orchimd guitsetgesen maltlaga sudalgaany uridchilsan ur dun. *Mongolyn arkheologi-2025*. Erdem shinjilgeenii khurlyn emkhetgel. Ulaanbaatar, 2025: 390-396.

Enkhtur A., Batbold G., Bayarsaikhan M., Mongol-Turkiin khamtarsan “Tuulyn Khundii dekh Khukh Tureg, Uiguryн suuringuud” tusliin arkheologiin maltlaga sudalgaany ajlyn tailan. SHUA-iin Arkheologiin khureelengiin GBSKH. Ulaanbaatar, 2025: 89.

Klimov P., Geriin amitdyn anatomi. I boti. Ulaanbaatar, 1969: 529.

Angela von den Driesch. A Guide to measurement of animal bones from archaeological sites. Peabody Museum of Archaeology and Ethnology. Harvard University, 1976. 137.



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.


See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>




Зураг 1. 1-р булинаас илэрсэн үхрийн толгойн ясыг дагтарисан шорооноос нь цэвэрлэж буй байдал, Үхрийн толгойн ясыг дээд талаас нь авсан зураг




Зураг 2. 1-р булинаас илэрсэн үхрийн толгойн ясыг хажуу талаас авсан зураг, Үхрийн толгойн ясны хажуу талын гар зураг



Зураг3. 1-р булинаас илэрсэн үхрийн толгойн доод эрүүний ясыг дээд талаас авсан зураг, Үхрийн толгойн доод эрүүний ясны гар зураг



Зураг 4. 1-р булинаас илэрсэн үхрийн доод эрүүний яс, Үхрийн доод эрүүний ясны гар зураг



Зураг 5. 1-р булинаас илэрсэн адууны толгойн ясны дээд тал,
Адууны толгойн ясны гар зураг



Зураг 6. 3-р булинаас илэрсэн хонины толгойн ясны дээд гадаргуу,
Хонины толгойн ясны доод гадаргуу



Зураг 7. 6-р булинаас илэрсэн нохойн
доод эрүү, шүд



Зураг 8. 3-р булинаас илэрсэн богийн яс



Зураг 9. Төмстийн өврийн 1-р булинаас илэрсэн хүний оршуулга



Зураг 10. Төмстийн өврийн 1-р булинаас илэрсэн мал, амьтны яс



Зураг 11. Төмстийн өврийн 3-р булинаас илэрсэн хүн, малын яс



Зураг 12. Төмстийн өврийн 6-р булинаас илэрсэн хойлгын нохой